



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 4/33

Хэрлэн сум

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа гаргаж,  
гамшгаас хамгаалах төлөвлөгөөг  
шинэчлэн боловсруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12, Шадар сайдын 2018 оны 67, 120, 125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааг гаргаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг гаргаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг зааврын дагуу боловсруулан 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор батлуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Сум, тосгон, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, байгууллага аж ахуйн нэгжийн эрсдэлийн тойм судалгаа, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дээрх хугацаанд шинэчлэн боловсруулахыг сумын Засаг дарга, Тосгоны захирэгч, Гамшгаас хамгаалах орон нутгийн албад, байгууллага аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Сонцгой байдлын газрын дарга дэд хурандаа /Н.Чанцал/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ  
 ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Бүрэлдэхүүн	Овог нэр	Албан тушаал
1	Ажлын хэсгийн ахлагч	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
2	Гишүүд	Н.Чанцал	Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа
3		Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
4		Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, хурандаа
5		С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
6		Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэтсийн дарга
7		Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
8		Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
9		Ц.Гэрэлмаа	Эрүүл мэндийн газрын дарга
10		Ж.Болд	Цагдаагийн газрын дарга
11		Х.Ганчулуун	Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга
12		Ч.Алтанзаяа	Зам арчлалтын "Харгуй ТӨХК"-ны захирал
13		Б.Дархантөр	Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
14		Г.Чулуун	Ус цаг уур орчны шинжилгээний албаны дарга
15		Г.Батгэрэл	Нийтийн ахуй үйлчилгээний Хэнтий ус ХХК-ны захирал
16		О.Од-Эрдэнэ	"Мэдээлэл холбоо сүлжээ" ХХК
17		Д.Баярхүү	Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга
18		Т.Өлзийсүрэн	Статистикийн хэлтсийн дарга
19		Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
20		Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
21		Нарийн бичгийн дарга	Р.Батсайхан